

# ХЭНТИЙ АЙМГИЙН МӨНГӨН ХУРИМТЛАЛЫН БҮЛГҮҮДИЙН ХОЛБОО

Хэнтий аймгийн МХБХ-ны 2013-2020 онуудад хийсэн ажлын товч тайлан

Хүний эрх хөгжил төвийн дэргэдэх Хэнтий аймаг дахь салбар Мөнгөн хуримтлалын бүлгүүдийн холбоо нь 2013 оны 06 сард байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байгаа билээ. Уг холбоо нь орон нутгийн иргэдийн ядуурлыг бууруулах, бүлэг болон хамтарч ажиллах нөхцөл болмжийг бүрдүүлж хамт олонд суурилсан олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулж хөдөөгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, орлого багатай эмэгтэйчүүдийг бүлэг болгон хамтран ажиллахад тусалж тэдэнд орон байр, эрүүл мэнд боловсролын чиглэлээр үйлчилгээ үзүүлэх, ур чадвар нэмэгдүүлэх сургалтуудыг зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг хамтран зохион байгуулж байна.

Холбоонд ХОХС, сургалт, хэвлэл мэдээлэл, орон байр, эрүүл мэндийн зөвлөл гэсэн бүтэцтэй бөгөөд холбооны үйл ажиллагааг 2013-оны 7-р сараас эхлэн Хэрлэн Мөрөн суманд 7 бүлгийн 85 гишүүдтэй үйл ажиллагаа явуулан ажиллаж байна.

- Бүлгийн гишүүдийн орон байрны нөхцөл сайжруулах тусламжийг 7 өрхийн 59 гишүүдэд 6998,0 төгрөгийн тусламж үзүүлэн орон байраа сайжруулсан байна.
- Мөн бүлгийн бизнесийг дэмжих зорилгоор 3 бүлгийн 31 өрхийн 101 гишүүдэд бизнесээ өргөжүүлэх 6000,000 төгрөгийн зээлийг олгон амжилттай хэрэгжүүлсэн.
- Холбооны гишүүдийн орон байр, ОО-ын нөхцөл сайжруулах зорилгоор ХЭХТ-өөс 9000,000 төгрөгийн зээлийг 26 өрхийн 120 гишүүдэд олгож 19800,000 төгрөгөөр орон байраа сайжруулсан байна.
- 2017 онд холбооны оёдолын бүлгийн гишүүдэд үйлдвэрийн оёдлын машин, хэрээсний машин, индүү, гутлын оёдлын машин, үрэгч зэрэг 12 машин тоног төхөөрөмж, ногооны бүлгүүдэд усалгааны систем, ногоо үрлэгч, 20х6 хүлэмж 3, сүү машиндагч 8 зэрэг багаж тоног төхөөрөмжүүдийг 80 %-ийн хөнгөлөлттэй үнээр олгож нийт 50 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг олон улсын төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр олгосон нь үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломжыг нэмэгдүүлсэн болно.

## ХЭНТИЙ АЙМГИЙН МӨНГӨН ХУРИМТЛАЛЫН БҮЛГҮҮДИЙН ХОЛБОО

Холбоо 2013-2020оны хооронд ХЭХТ болон АККА –гаас дараах төслүүдийг амжилттай хэрэгжүүлж ирсэн.

Он	Бүлгийн нэр	Төслийн нэр	Санхүүжилт					Үр шимийг хүртэгчид		Үр дүн
			АККА	ХЭХТ	Орон нутаг ЗДТГ	Бусад	Нийт дүн	Өрхийн тоо	Хүний тоо	
2013				1000.0						МХБХ-ны гишүүдийн бизнесийг өргөжүүлэхэд зориулагдсан
2013		Орон байрны нөхцөл сайжруулах	500\$ 720.0			106.0	806.0	1	7	Олны хүч бүлгийн гишүүн Л.Нандинчимэг 6 хүүхэдтэй ӨТЭ-н гэрийг засаж сайжруулан өгсөн
2014	Цэцэглэн, Дэлгэр	Орон байрны нөхцөл сайжруулах	1000\$ 1700.0			500,0	2300,0	2	14	Мөрөн сумын Цэцэглэн бүлгийн гишүүн Эрдэнэхуяг, дэлгэр бүлгийн гишүүн Наранбаатар нарын олон хүүхэдтэй залуу гэр бүлүүдийн орон байрны нөхцөлийг сайжруулахад хамт олноороо хамтарч ажилласан
2014		Цэвэр орчин эко ОО		3000,0		800,0	3800,0	8	40	Хэрлэн сумын 8 бүлгийн өрхийн амьдрах орчны нөхцөл сайжирч ОО асуудлаа сайжруулсан
2015	Насны нүнжиг	Бүлгийн бизнесийг өргөжүүлэх		3000,0			3000,0	13	33	Бүлгийн гишүүдийн бизнесийг өргөжүүлэх үйл ажиллагаанд зориулсан
2015	Баян-Ундарга, Өсөндэвжих	Орон байрны нөхцөл сайжруулах	1000\$ 1990,0				1990,0	2	15	2 өрхийн орон байрны нөхцөл сайжруулсан
2016	Хамтын хүч	Модон эдлэлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх		2000,0			2000,0	11	40	Хамтын хүч бүлгийн Модон эдлэлийн цехийн үйл ажиллагааг өргөжүүлэн бүлгийн гишүүдийн орлого нэмэгдүүлэн ажиллах
2016	Цэцэглэн	Хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх		1000,0			1000,0	7	28	Төсөл хэрэгжүүлсэнээр бүлгийн гишүүдийн тариалах ногооны хэмжээ нэмэгдэж өрхийн орлого дээшилсэн үр дүнтэй
2016	МХБХ	Холбооны гишүүдийн орон байрны нөхцөл сайжруулах		3000,0			3000,0	12	60	МХБХ-ны 6 бүлгийн 12 гишүүний орон байрны нөхцөл сайжирсан үр дүнтэй байна.
2016	Хамтын хүч, Насны нүнжиг	Орон байрны нөхцөл сайжруулах	1000\$ 1982,0				1982,0	24	73	2 бүлгийн гишүүний орон байрны нөхцөл сайжирсан
2019	Хамтын хүч, насны нүнжиг, олны хүч	Орон байрны нөхцөл сайжруулах		3000,0		10,000,0	13000,0	6	20	Насны нүнжиг бүлэг 2 өрх, хамтын хүч бүлэг 2өрх, олны хүч бүлэг 2 өрх нийт 6 өрх орон гэрээ засаж сайжруулсан
			3500\$ 6392,0	16000,0		10406,0	32878,0	203	310	

## ХЭНТИЙ АЙМГИЙН МӨНГӨН ХУРИМТЛАЛЫН БҮЛГҮҮДИЙН ХОЛБОО

Хэнтий аймгийн Мөнгөн хуримтлалын бүлгүүдийн холбооны 2021оны тайлан

Манай аймгийн МХБ-хувьд өнгөрч байгаа 2021онд дэлхий нийтийг хамарсан цар тахалын хөл хориотой хүнд хэцүү жил болж өнгөрлөө. Энэ үед бас шинэ орчинд ажиллаж сурах шаардлага тулгарч цахим орчинд ажиллах суралцаж эрэлт хэрэгцээтэй болсон байна. Бид өнгөрсөн онд цахим хурал, сургалт, хэлэлцүүлэгт оролцон санал бодол, үг хэлэх зэрэгээр оролцоогоо хангаж ажиллаа.

Нөлөөлөл ба харилцааны олон улсын сургалтанд 4сарын 26-30 өдрүүдэд цахимаар оролцон мэдлэг мэдээлэл дадал чадвараа сайжрууллаа. Мөн APWLD- зүүн азын бүсийн олон улсын хуралд 5сарын 10-12 өдрүүдэд оролцлоо.

Газрын багц хуулийн хэлэлцүүлэгт бүлгийн гишүүдийн хамтаар цахим саналд 70гаран санал оруулан оролцлоо.

Жил бүр уламжлал болон зохиогддог туршлага судлах уулзалтандаа цахимаар оролцон өөрийн холбооны хийсэн ажил болон санал сэтгэгдэлээ бусадтайгаа хуваалцлаа.

Дэлхийн хүнсний өдрийг тохиолдуулан хэрлэн сумын зорилтод 10 өрхөөс хүнсний эрхийн судалгаа авч нэгтгэн явуулсан. Өнгөрч буй он манай холбооны хувьд бас зовлон гуниг хагацал тохиолдсон жил байлаа. Мандах наран бүлгийн гишүүн Д.Осоржамаа, мөрөн сумын Дэлгэр бүлгийн гишүүн Алтантогос нар маань зуурдаар нас барсан эмгэнэлтэй үйл явдал тохиолдсон. Энэ хүнд өдрүүдийг бид гэр бүлийнх нь хамтаар уй гашууг нь хуваалцан мөнгө төгрөг, сэтгэл санааны дэмжлэг үзүүлсэн. Бүлгийн гишүүдээс нэлээн олон хүмүүс Ковид -19 халдаварт өвчинөөр өвчилж эдгэрсэн.

Монгол улс дахь иргэний орон зай судалгааг цахимаар 4 иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгч нараар бөглүүлэн оролцсон.

Олон улсын хүний эрхийн өдрөөр эрхээ шаардъя аянд нэгдэж үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхээ шаардан үг хэлж, эрхээ шаардан оролцлоо. Оны эхний хагас жилд гишүүдийн бизнесийн үйл ажиллагаа бүрэн зогссон байсан учраас өрхийн орлого буурсан. Одоогоор хэвийн үйл ажиллагаанд орж эхэлж байна.

Тайлан бичсэн: МХБХ-ны дарга Д.Уранчимэг